



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/422

Булган сум

**Архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх,  
хэрэглэхийг хориглох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих архидан солгтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр-хүүхдийн баяр”-ыг аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй өдөр болгон тэмдэглэсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр-хүүхдийн баяр” 2023 оны 6 дугаар сарын 01-ний өдөр архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, хэрэглэхийг хориглосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Л.Ганбаатар)-т даалгасугай.

4. Захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, бүх сумын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010414